



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 06 өдөр

Дугаар А/273.

Мандалговь

Бруцеллезын дархлаажуулалтыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.2 дахь хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7 дахь заалтууд, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн А/179 дүгээр тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг 2021 оны 08 дугаар сард багтаан зохион байгуулсугай.

2. Бруцеллэзын вакцинжуулалтад хамрагдах төлийн тоо, вакцины хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан бруцеллэз өвчний вакцинжуулалт хийх ажлын удирдамжийг баримтлан тогтоосон хугацаанд төл (тугал, хурга, ишиг) малаа бүрэн хамруулан зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт, Мэргэжлийн удирдлага, арга зүйгээр ханган чанартай зохион байгуулахыг Мал эмнэлгийн газар (Ш.Мөнхдүүрэн)-т, захирамжийн хэрэгжилтийг хангуулж, 2021 оны 10 дугаар сарын 01-ний дотор тайлагнахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210823